



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.12.28 № 2/6629

танай 2023.12.15-ны № 03/329/-Т

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД  
Х.БУЛГАНТУЯА ТАНАА**

“Журам шинэчлэн батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/155 дугаар тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн .....<sup>65/8</sup> дугаарт бүртгэж хүргүүлэв.

ДЭД САЙД



Б.СОЛОНГОО

151904454 Doc. yam. a5. 2023



МОНГОЛ УЛСЫН  
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн бүртгэлд  
2023 оны 12 сарын 28-ны  
өдрийн 65/8 дугаарт бүртгэв.

2023 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/155

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг ажил олгогчдод, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх итгэмжлэл бүхий төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/-т, хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн захирал /М.Даваабат/-д тус тус даалгасугай.



4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "Журам шинэчлэн батлах тухай" Хөдөлмөрийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/223 дугаар, "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үнэлгээ хийх жишиг үнийг шинэчлэн батлах тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/75 дугаар тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД



Х.БУЛГАНТУЯА



151230427

D: 2023 on 11 sar tushaal



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын  
2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн  
А/15 дугаар тушаалын хавсралт



## АЖЛЫН БАЙРНЫ ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх, байгууллагад тавигдах шаардлага, зохион байгуулалт, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний цахим мэдээллийн сан, хяналт, шалгалт, хариуцлагын талаарх харилцааг зохицуулна.

1.2. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ нь ажилтны ажиллах чадвар, эрүүл мэндэд нь дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байр, үйлдвэрлэлийн орчны хими, физик, сэтгэлзүй, физиологи, биологийн хортой хүчин зүйлсийн өртөлтийг хэмжин тодорхойлж, үр дүнг хөдөлмөрийн эрүүл ахуйн стандартаар тогтоосон зөвшөөрөгдөх хэмжээтэй харьцуулан дүгнэж, эрсдэлийг үнэлж, ажилтны эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг төлөвлөх нотолгоог бий болгох нэгдмэл үйл ажиллагаа болно.

1.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт заасны дагуу ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг "MNS ISO/IEC 17020, Тохирлын үнэлгээ. Хяналтын ажил эрхэлдэг төрөл бүрийн байгууллагын ажиллагаанд тавих шаардлага" стандартын итгэмжлэлтэй төрийн болон хувийн хэвшлийн хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн байгууллага энэ журмыг үндэслэн хийнэ.


1.4. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, ажил олгогч нь хөрөнгө оруулалт, өмчийн хэлбэрээс үл хамааран Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалтад заасны дагуу ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх үүргийг хүлээнэ.

### Хоёр. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх байгууллага

2.1. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1 Хэмжил зүйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт зааснаар шалгалт тохируулгад, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт зааснаар шалгалт баталгаажуулалтад хуваарийн дагуу тогтмол хамрагддаг хэмжилт, сорьц цуглуулалтын багаж, хэрэгсэлтэй байх;

2.1.2 Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх байгууллага нь хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт, үнэлгээний арга зүйг эзэмшсэн, ажил мэргэжилтэй холбоотой өвчнөөс урьдчилан сэргийлэлтийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үр нөлөөг нь





үнэлэх чадамжтай орон тооны хөдөлмөрийн эрүүл ахуйн төрөлжсөн мэргэшил эзэмшсэн мэргэжилтэнтэй байх.

2.2. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх байгууллага нь итгэмжлэлийн хүрээнд хамрах үзүүлэлтээр хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт судалгаа, үнэлгээг явуулна.

2.3. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд "MNS ISO/IEC 17025, Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага" стандартаар итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүнг ашиглана.

2.4. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайланг MNS 5080:2023 стандартын 4.3.6 дахь заалтын дагуу хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн холбоогоор мэргэжлийн чадамжаа баталгаажуулсан "мэргэшсэн хөдөлмөрийн эрүүл ахуйч" хянаж, гарын үсэг зурж баталгаажуулна.

### **Гурав. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх зохион байгуулалт**


3.1. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийхэд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, Хэмжил зүйн тухай хууль, "MNS 5080:2023, Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, үнэлгээнд тавигдах шаардлага", "MNS 4990:2023, Ажлын байрны агаар дахь хорт бодисын хэмжилд тавигдах ерөнхий шаардлага, зөвшөөрөгдөх дээд хэмжээ" стандарт, бусад хөдөлмөрийн эрүүл ахуйн стандартыг мөрдлөг болгоно.

3.2. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний зохион байгуулалт нь MNS 5080:2023 стандартад заасан ерөнхий шаардлагыг хангах бөгөөд хэмжилт, сорьц цуглуулалтын түүврийн тоо нь үнэлгээнд хамрагдах ажлын байр эсвэл ижил өртөлтийн бүлгийн ажилтнуудын өртөлтийг статистикийн хувьд хүчин төгөлдөр төлөөлөхүйц байна.

3.3. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх хуулийн этгээд, ажил олгогч нь энэ журмын 1.3-т заасан итгэмжлэл бүхий байгууллагад хүсэлт гаргаж, гэрээ байгуулсны үндсэн дээр уг үнэлгээг хийлгэх бөгөөд гэрээнд талуудын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагын талаар тодорхой тусгана.

3.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт зааснаар ажлын байр шинээр бий болгох болон тухайн ажлын байрны үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, нөхцөл өөрчлөгдөх бүрд нь, химийн хорт болон аюултай бодис агуулсан түүхий эд, материал ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа бол жилд 1-ээс доошгүй удаа ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэнэ.

3.5. Шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө ажил олгогч, ажилтны хүсэлт, эрх бүхий байгууллагын шийдвэрээр хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэж болно.





3.6. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээгээр хэвийн нөхцөлтэй нь тогтоогдсон, эрсдэлгүй ажлын байранд 5 жил, дунд эрсдэлтэй ажлын байранд 3 жил тутамд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийж, эрсдэлийн түвшинд хяналт тавина.

3.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээгээр ажилтны эрүүл мэндэд өндөр, ноцтой эрсдэлтэй нь тогтоогдсон ажлын байранд эрсдэлийг арилгах, бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг ажил олгогч хүлээнэ.

3.8. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх байгууллага нь хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийсэн тайлан, зөвлөмжийг ажил гүйцэтгэх гэрээнд заасан хугацаанд өгнө.

3.9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу ажил олгогч нь ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайланг ажилтнуудад танилцуулна.


3.10. Ажил олгогч хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайланг хүлээж авснаас хойш 12 сарын дотор ажлын байрны эрсдэлийг арилгаж, бууруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн тайланг фото зураг, видео бичлэгээр баталгаажуулан үнэлгээ хийсэн итгэмжлэгдсэн байгууллагад хүргүүлнэ.

3.11. Ажил олгогч нь ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээгээр хэвийн бус нөхцөлтэй нь тогтоогдсон эрүүл мэндийн өндөр эсхүл ноцтой эрсдэлтэй ажлын байранд жилд 1-ээс цөөнгүй удаа хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэж, ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг хянаж, урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээний үр нөлөөг тогтмол үнэлнэ.

3.12. Ажлын байрны эрсдэлийг бууруулах дэс дараатай арга хэмжээг хамгийн боломжит түвшинд тогтмол хэрэгжүүлдэг боловч үйлдвэрлэлийн технологи, ажлын онцлогоос хамааран эрүүл мэндийн өндөр, ноцтой эрсдэлийг нь арилгах боломжгүй нь тогтоогдсон хэвийн бус нөхцөлтэй ажил, мэргэжлийг тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох ажил мэргэжлийн жагсаалтад оруулах саналыг ажил олгогч мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллагад гаргана.

3.13. Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага нь энэ журмын 3.12-т заасан ажлын байранд хийсэн хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайлан, тогтмол хэрэгжүүлдэг эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан, үйлдвэрлэлийн технологи, ажлын онцлогоос хамаарсан эрсдэлийн шинж чанарын хэрэгжилтийн тайланг төвийн дэргэдэх хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны хуралд танилцуулан шийдвэрлүүлнэ.

3.14. Энэхүү журмын 3.13-т заасан мэргэжлийн зөвлөл нь мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага болон хөндлөнгийн үнэлгээний байгууллагын төлөөлөл тус бүр 2, мэргэжлийн холбоо, хяналт шалгалт





хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын төлөөлөл тус бүр 1, мэргэжлээс шалтгаалсан өвчин судлаач эмчийн төлөөлөл 1, нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй байна.

3.15. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт заасны дагуу ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайланг ажилтны эрүүл мэндийн үзлэг тандалт, мэргэжлээс шалтгаалсан өвчний оношны магадалгаанд ашиглах зорилгоор 16 жил хадгална.

3.16. Энэхүү журмын хавсралтаар баталсан ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үнэлгээ хийх жишиг үнийг итгэмжлэл бүхий төрийн байгууллага үйл ажиллагаандаа мөрдөнө.

3.17. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний зардлыг хуулийн этгээд, ажил олгогч хариуцна.

### **Дөрөв. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний цахим мэдээллийн сан**

4.1. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх байгууллага мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллагад бүртгүүлж, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний үр дүнгээр өгөгдлийн сан (цаашид "өгөгдлийн сан" гэх) үүсгэн, бүртгэл хөтөлж, тайланг хүргүүлнэ.


4.2. Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага нь өгөгдлийн санд тулгуурлан хөдөлмөрийн нөхцөлийн цахим мэдээллийн сан (цаашид "мэдээллийн сан" гэх) үүсгэж, хагас жил тутам шинэчилнэ.

4.3. Цахим мэдээллийн сан нь хөдөлмөрийн эрүүл ахуйн талаарх төрийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг үнэлэх, төрийн хяналт шалгалтыг төлөвлөх, олон нийтэд мэдээлэх, төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох, судалгаа эрдэм шинжилгээнд ашиглах, бусад цахим үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

4.4. Итгэмжлэгдсэн байгууллага нь ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний мэдээллийг энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний өгөгдлийн сан"-гийн маягтын дагуу бүртгэж, хөтөлнө.

4.5. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх байгууллага нь хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний үр дүнг тухай бүр мэдээллийн санд оруулж, үнэн зөв байдлыг нь хариуцна.

4.6. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх байгууллага нь энэ журмын 4.4-т заасан мэдээллийн нууцлалыг, мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага нь энэ журмын 4.2-т заасан мэдээллийн нууцлалыг хадгална.





## Тав. Хяналт шалгалт

5.1. Хяналт, шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх байгууллагын үйл ажиллагаа, цахим болон цаасан бичиг баримт, мэдээллийн санд хяналт тавьж ажиллана.

5.2. Хүн, хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтийн дагуу хяналт, шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хяналт, шалгалт хийж байна.

5.3. Хяналт, шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь цахим мэдээллийн санд үнэлгээ, дүгнэлт хийж, өндөр, ноцтой эрсдэлтэй үнэлэгдсэн болон ажлын байрны эрсдэлийг арилгаж, бууруулах арга хэмжээ аваагүй, холбогдох тайланг ирүүлээгүй ажил олгогчид эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авна.

5.4. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх байгууллагын итгэмжлэлийн үнэлгээнд шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хөндлөнгийн хяналт тавьж болно.

## Зургаа. Хариуцлага

6.1. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг үнэлэхдээ Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.2, Хэмжилзүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, MNS 5080:2023 стандарт болон энэхүү журмыг зөрчсөн, хөдөлмөрийн нөхцөлийг хэмжилт, шинжилгээнд үндэслэхгүйгээр бодитой бус үнэлсэн, багажийн болон лабораторийн шинжилгээг хуурамчаар үйлдсэн, стандартын шаардлага хангаагүй тайлан дүгнэлт гаргасан хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх бөгөөд итгэмжлэлийг нь түдгэлзүүлэх саналыг Үндэсний итгэмжлэлийн төвд гаргана.


6.2. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний үр дүнд хөндлөнгөөс нөлөөлсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

6.3. Ажлын байрны өндөр, ноцтой эрсдэлийг арилгаж, бууруулах арга хэмжээ аваагүй ажил олгогчид холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

6.4. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээтэй холбогдох асуудлыг тухайн ажлыг гүйцэтгэсэн үнэлгээний байгууллага хариуцна.

6.5. Давуу байдлаа хууль бусаар ашигласан, дүрэм, журам зөрчсөн хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн зөвлөлийн гишүүдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

6.6. Энэхүү журмын 3.12-т тусгасан эрүүл мэндийн өндөр, ноцтой эрсдэлийг нь арилгах боломжгүй нь тогтоогдсон хэвийн бус нөхцөлтэй ажил, мэргэжлийг тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох ажил мэргэжлийн жагсаалтад оруулах саналыг бодитоор үнэлээгүй, үндэслэлгүй оруулсан нь төвийн дэргэдэх хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн зөвлөлийн хурлаар тогтоогдвол хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ



хийсэн байгууллагын итгэмжлэлийг хүчингүй болгох талаар холбогдох байгууллагад санал хүргүүлнэ.


6.7. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх байгууллага нь тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох ажил мэргэжлийн жагсаалтад багтсан ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг үнэлэхдээ бодит хэмжилт, шинжилгээнд үндэслээгүй бол энэхүү журмын 6.1-т заасны дагуу хариуцлага хүлээнэ.

6.8. Энэхүү журмыг зөрчсөн хүн, баримтаар тогтоогдсон гэм буруутай хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

... оОо ...



6






Ажлын байрны хөдөлмөрийн  
нөхцөлийн үнэлгээ хийх  
оурмын нэгдүгээр хавсралт


**АЖЛЫН БАЙРНЫ ХӨДӨЛМӨРИЙН  
НӨХЦӨЛД ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖИШИГ ҮНЭ**

-	Хэмжилтийн нэр		Ашиглах тоног төхөөрөмж	Үнэлгээний тариф /төгрөг/
<b>А.Хөдөлмөрийн нөхцөлийн физик хүчин зүйлийн хэмжилт</b>				
1	Агаарын температур /C°/		Термометр	10 000
2	Агаарын харьцангуй чийглэг		Психометр	10 000
3	Гэрэлтүүлэг		Люксметр	7 000
4	Байгалийн гэрэлтүүлгийн коэффициент		Люксметр тооцоолол	9 000
5	Шуугиан	Шуугианы түвшин хэмжигчээр	Шуугианы түвшин хэмжигч	15 000
		Хувь хүний дозиметрээр		42 000
6	Доргион	Бүх биед дамжих	Виброметр	45 000
		Гарт дамжих		45 000
7	Агаарын урсгалын хурд		Анемометр	9 000
8	Агаарын даралт		Барометр	5 000
9	Цахилгаан соронзон орон, радио давтамж		Цахилгаан соронзон орон хэмжигч	15 000
10	Дулааны цацраг		Дулааны цацраг хэмжигч	11 000
11	Ионжуулагч цацраг		Ионжуулагч цацраг хэмжигч	15 000
12	Ажлын байрны тоосны хэмжилт /мг/м <sup>3</sup> /	Нийт тоос	-	40 000
		Цулцанд нэвтэрдэг тоос		55 000
		Гагнуурын тоос		55 000
		Кварц цахиур тодорхойлох		41 000
<b>Б.Хөдөлмөрийн физиологийн хэмжилт</b>				
1	Цусны даралт хэмжих, пульс тоолох /нэг ажилтан/		Даралтын аппарат	1 000
2	Асуумж судалгаа /нэг ажилтан/		-	1 000
3	Ажил мэргэжилтэй холбоотой ядралтын зэрэг тодорхойлох		-	30 000
4	Ажилтны хөдөлмөрийн чадвар түр алдалт өвчлөлийн судалгаа хийх дүгнэлт гаргах		-	25 000
5	Эргономик		-	7 000





<b>В.Биологийн шинжилгээ</b>			
1	Ажлын байрны орчин дахь бактери	-	25 000
2	Ажлын байрны орчин дахь мөөгөнцөр	-	22 000
<b>Г.Химийн шинжилгээ</b>			
<b>Химийн бодисын нэр</b>		<b>CAS дугаар</b>	
1	Аммиак	7664-41-7	25 000
2	Азотын ислүүд	10102-44-0	22 000
3	Аналин	62-53-3	20 000
4	Ацетон	67-64-1	28 000
5	Бензол	71-43-2	35 000
6	Ксилол	95-47-6	35 000
7	Толуол	108-88-3	35 000
8	Бромт устөрөгч	10035-10-6	30 000
9	Бутилийн спирт	71-36-3	20 000
10	Бутил ацетат	123-86-4	20 000
11	Бензин	86290-81-5, 8032-32-4	32 000
12	Керосин	8008-20-6	26 000
13	Цагаан спирт /Стоддарт уусмал/	8052-41-3	15 000
14	Вольфром түүний органик биш нэгдлүүд	7440-33-7	20 000
15	Гранизон	-	18 000
16	Гидрохинон	123-31-9	18 000
17	Гексахлоран	319-84-6, 319-85-7	19 500
18	Гидрозин	302-01-2	22 000
19	Дихлордифенилтрихлорэтан	50-29-3	20 500
20	Диоксан	123-91-1	33 000
21	Дихлорэтан	75-34-3	25 000
22	Дифенилгуандин	-	18 500
23	Диэтилпарафенилендиамин	-	17 500
24	Иод түүний нэгдлүүд	7553-56-2	19 000
25	Исэлдэх чанар	-	19 000
26	Зэс түүний нэгдлүүд	-	18 000
27	Ксантоген	-	18 000
28	Карбофос	121-75-5	18 000
29	Трикрезол /Орто-, мета-, пара-/	1319-77-3/95-48-7, 108-39-4, 106-44-5/	17 000
30	Метилийн спирт	67-56-1	19 000
31	Марганц түүний исэл	Олон дугаартай	20 000
32	Марганц хүчлийн кали	7722-64-7	20 000
33	Мөнгөн ус /метал хэлбэрт/	7439-97-6	23 000
34	Молибден түүний нэгдэл/Молибден силицид/	12136-78-6	25 000
35	Нүүрстөрөгчийн дутуу исэл /CO/	630-08-0	21 000
36	Нүүрстөрөгчийн давхар исэл	124-38-9	21 000
37	Никель /металл/	7440-02-0	21 000






38	Никелийн исэл ба түүний органик бус нэгдлүүд	1313-99-1	21 000
39	Никель карбонил	13463-39-3	21 000
40	Никелийн сульфид	12035-72-2	21 000
41	Нафталин	91-20-3	21 000
42	Озон /Оз/	10028-15-6	20 000
43	Поливинилийн спирт	-	16 000
44	Дөрвөнхлортэтилен	127-18-4	21 000
45	Тетраметил тиураминдисульфид	-	17 500
46	Селен аморфи	7782-49-2	20 000
47	Селений ангидрид	715/7783	20 000
48	Селений гексафторид	7783-79-1	20 000
49	Селенид цайр /идэвхижсэн зэс, кадмийн/	7782-49-2	20 000
50	Скипидар	8006-64-2	21 500
51	Трихлорэтилен	79-01-6	19 000
52	Төмөр /таван карбонилт/	13463-40-6	21 000
53	Төмөр /Хүнцэл агуулсан/	7439-86-9	21 000
54	Хөнгөн цагаан аммонийн сульфид	7784-26-1	21 000
55	Төмрийн исэл /3% хүртэл марганцын исэл агуулсан/	1309-37-1	21 000
56	Теллур	13494-80-9	22 000
57	Тиосульфат аммон	7783-18-8	18 000
58	Фенол	108-95-2	19 000
59	Формальдегид	50-00-0	21 000
60	Гидроперекись /3-дагч амилийн ба бутилийн/ Ус төрөгчийн хэт исэл	7722-84-1	18 000
61	Фторт кальци	7789-75-5	18 000
62	Фторт ус төрөгч	7664-39-3	18 000
63	Фосфор/шар/	7723-14-0	30 000
64	Фосфор хүчлийн бари /3 халах/	13847-18-2	30 000
65	Фосфор хүчлийн хром /3 халах/	7789-04-0	30 000
66	Фосфорын пентасульфат	1314-80-3	30 000
67	Фосфорын гуравч исэл	1314-24-5	30 000
68	Фосфорын тавч исэл	1314-56-3	30 000
69	Фосфорын хүчил	7664-38-2	30 000
70	Фенил 13 нафталин	-	20 500
71	Фенозин 23	-	18 000
72	Хүхрийн хүчил /хүхэрт ангидрид боз/	7664-93-9	21 000
73	Хүхэрлэг ангидрид	7646-11-9	19 000
74	Хүхэрт ус төрөгч	7783-06-4	20 000
75	Хлорфос	52-68-6	20 000
76	Хром хлорт /гексангидрат, трихлорид/	10060-12-5	21 000
77	Хром, фосфор, никелийн кальци	13765-19-0, 7758-87-4	21 000
78	Хромын исэл /II, III, IV, VI/	Олон дугаартай	21 000
79	Хромил хромид	14977-61-8	21 000





80	Хлоропрен	126-99-8	30 000
81	Хар тугалга	7439-92-1	22 000
82	Хөө тортог /нүүрстөрөгч/	1333-86-4	30 000
83	Хлорт ус төрөгч /Давсны хүчил/	7647-01-0	20 000
84	Хлорын хий	7782-50-5	20 000
85	Хлорфром	67-66-3	22 000
86	Цууны хүчил	64-19-7	21 000
87	Циант ус төрөгч /синилийн хүчлийн давс/	74-90-8	22 000
88	Идэмхий шүлт /натрийн шүлт/	1310-73-2	19 000
89	Калийн гидроксид	1310-58-3	19 000
90	Кальцийн гидроксид	1305-62-0	19 000
91	Цахиурт фтор натри	-	15 000
92	Этилийн спирт	64-17-5	19 000
93	Этилийн эфир, метакрилийн хүчилтэй	97-63-2	19 000
94	Этилийн эфир, фенолтой /фенотол/	103-73-1	19 000
95	Этилийн эфир, хризантемын хүчилтэй	97-41-6	19 000
96	Метилэтилкетон	78-93-3	21 000
97	Дихлорфос	-	21 500
98	Хүнцэл /мышьяк/	7784-42-1	22 000
99	Хүнцэл, хүнцэлийн ангидрид	7440-38-2	22 000
100	Хүнцэл хүчлийн цезий	16331-85-4	22 000
101	Бромфром	75-25-2	25 000
102	Метан /CH <sub>4</sub> /	74-82-2	19 000
103	Карбондисульфид /Хүхэрт нүүрстөрөгч CS <sub>2</sub> /	75-15-0	17 000
104	1-50 ажилтан		25 000
	51-100 ажилтан		45 000
104	101-дээш	Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайлан бичих, ерөнхий зөвлөмж боловсруулах	80 000

... оОо ...



10





**Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний өгөгдлийн сангийн мавт**

Үнэлгээ хийсэн байгууллагын мэдээлэл:  
Бүртгэлийн дугаар \_\_\_\_\_  
Утасны дугаар \_\_\_\_\_

Үнэлгээний тайланг баталгаажуулсан хөдөлмөрийн эрүүл ахуйн мэдээлэл:  
Овог, нэр \_\_\_\_\_  
Утасны дугаар \_\_\_\_\_  
Имэйл хаяг \_\_\_\_\_

	Д/д
Нэр*	Үнэлгээнд хамрагдсан байгууллагын ерөнхий мэдээлэл (* тэмдэгтэй мэдээллийг ХНУ-ний нэгдсэн мэдээллийн санд илгээхгүй)
Регистрийн дугаар*	
Эдийн засгийн салбарын ангилал	
Эдийн засгийн дэд салбарын ангилал	
Улсын бүртгэлийн харьяалал	
Үнэлгээнд хамрагдсан ажлын	
Бүртгэлийн дугаар	
Өмнө нь ХНУ-нд хамрагдсан он	
ХНУ-нд хамрагдсан он, сар	
Нийт ажлын байрны тоо	
Үнэлгээнд хамрагдсан ажлын байрны тоо	
Нийт ажилтны тоо	
Үнэлгээнд хамрагдсан ажилтны тоо	
Эрсдэлгүй	Тоос, тоосонцрын өртөлтөөс хамаарсан эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний дүн (ажилтны тоогоор)
Дунд	
Өндөр	
Ноцтой	Химийн бодисын өртөлтөөс хамаарсан эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний дүн (ажилтны тоогоор)
Эрсдэлгүй	
Дунд	
Өндөр	Дулааны эсвэл/болон хүйтний стрессийн өртөлтөөс хамаарсан эрсдэлийн үнэлгээний дүн (ажилтны тоогоор)
Эрсдэлгүй	
Дунд	
Өндөр	Шуугианы өртөлтөөс хамаарсан эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний дүн (ажилтны тоогоор)
Эрсдэлгүй	
Дунд	
Өндөр	Гарт эсвэл/болон бүх биед дамжих доргионы өртөлтөөс хамаарсан эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний дүн (ажилтны тоогоор)
Эрсдэлгүй	
Дунд	
Өндөр	Ионжуулагч болон Ца.Со. цацрагийн өртөлтөөс хамаарсан эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний дүн (ажилтны тоогоор)
Эрсдэлгүй	
Дунд	
Өндөр	Гараар өргөх ачааны жингээс хамаарсан эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний дүн (ажилтны тоогоор)
Эрсдэлгүй	
Дунд	
Өндөр	Ядралтын зэргээс хамаарсан эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний дүн (ажилтны тоогоор)
Эрсдэлгүй	
Дунд	
Өндөр	Хэвийн хөдөлмөрийн нөхцөлтэй ажилтны тоо
ажлын байрны тоо	
ажилтны тоо	
ажлын байрны тоо	Урьдчилсан байдлаар хэвийн бус нөхцөлтэй
ажилтны тоо	
ажлын байрны тоо	Хэвийн бус нөхцөлтэй
ажилтны тоо	
ажлын байрны тоо	Хэвийн бусаас хэвийн нөхцөл рүү шилжсэн
ажилтны тоо	

